


БАРУУН БҮСИЙН БОСОО ТЭНХЛЭГИЙН АВТО ЗАМЫГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам БНХАУ-тай хил залгаа байрлах Ярантын хилийн боомтоос ОХУ-тай хиллэдэг Улаанбайшинтын хилийн боомт хүртэл 745.8 км урттай бөгөөд энэхүү корридор нь Монгол Улсын баруун бүс Ховд, Баян-Өлгий аймгаар дайран БНХАУ-ын Шинжаань бүс нутаг, ОХУ-ын Сибирийн бүстэй холбох Азийн авто замын АН-4, CAREC-ийн корридор 4“а” чиглэлийн нэг хэсэг юм.

Энэхүү корридорыг Азийн авто замын төлөвлөлтийн стандартыг хангахуйц асфальтбетон хучилттай авто замаар бүрэн холбосноор Монгол Улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг дэмжиж улмаар дамжин өнгөрөх ачаа, зорчигч тээвэрлэлтийн урсгалыг нэмэгдүүлж, дотоодын зах зээлийг хөгжүүлэхэд чиглэгдсэн Монгол улсын хувьд тээврийн стратегийн чухал ач холбогдолтой авто зам юм.



Энэхүү корридорыг бүхэлд нь хатуу хучилттай авто замтай болгох зорилгоор Монгол Улсын Засгийн Газар нь олон улсын банк санхүүгийн байгууллагуудтай тухайлбал Азийн Хөгжлийн Банк, БНХАУ-ын “ЕХИМ” банктай хамтран ажиллаж, үе шаттайгаар буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл авч хэрэгжүүлж байгаагаас 2011-2015 онд 359.4 км зам ашиглалтад оруулсан. Үүнд:

- АХБ-ны хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжаар:**
 - Тэмээн Хүзүү-Бага Улаан даваа чиглэлийн 110.8км,
 - Бага Улаан даваа-Манхан сум чиглэлийн 103.3км, нийт 214.1км асфальтбетон хучилттай авто зам,
- БНХАУ-ын “ЕХИМ” банкны хөнгөлөлттэй зээл:**
 - Өлгий-Хашаатын даваа чиглэлийн 60км,
 - Манхан-Ховд чиглэлийн 85.3км, нийт 145.3км асфальтбетон хучилттай авто зам,

Хоёр дахь үе шат буюу Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр доорх авто замын ажлыг 2015 оны 8 дугаар сараас барьж 2018-2019 онд улсын ашиглалтад хүлээлгэн өгсөн. Үүнд:

- **Багц CW1-1:** Хашаатын даваа-Шургийн гүүр чиглэлийн 50км авто замыг БНХАУ-ын “Чайна Хуаши Интерпрайзис” компани барьж 2018 онд ашиглалтанд оруулсан.
- **Багц CW1-2:** Шургийн гүүр-Ховд чиглэлийн 56.6км авто замыг БНХАУ-ын “Эйч Кэй Би Интернэйшнл Холдинг” компани барьж 2018 онд ашиглалтанд оруулсан.
- **Багц CW1-3:** Хашаатын даваа-Толбо чиглэлийн 60км авто замыг БНХАУ-ын “Чайна Хуаши Интерпрайзис” компани барьж 2019 оны 11 дүгээр сарын 16-нд улсын ашиглалтад хүлээлгэн өгсөн.
- **Мөст сумын 20.3 км авто зам:** 2018 оны 11 дүгээр сард Зам, Тээврийн Хөгжлийн яам нь “Хотгор Зам” ХХК-тай гэрээ байгуулсан ба ажлын явц 93.12%-тай, энэ оны 7 дугаар сард бүрэн дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна.
- **Өлгий хотыг тойрон өнгөрөх 18.82 км авто зам:** Энэ ажлыг 3 багц гэрээгээр гүйцэтгэхээр Зам, Тээврийн Хөгжлийн Яам нь авто замын барилгын гүйцэтгэгч “Эйч Кэ Би Интернэйшнл Холдинг” ХХК, “Хотгор Зам” ХХК-тай 2020 оны 3 дугаар сарын 27-ны өдөр гэрээ байгуулсан ба Захиалагчаас 2020.05.06-ны өдөр улаан шугам хүлээлгэн өгсөн. Багц-1-ийн замын трассын гадаслагаа хийгдэж дууссан, хэмжилтийн ажлууд, талбайн цэвэрлэгээ, өвс ногоог хуулах ажил хийгдэж байгаа. 1.6км өнгөн хөрс хуулах ажил хийгдсэн. Чулуун карьерын материалын шинжилгээ төв лабораторид хийгдсэн. Гэрээ ёсоор Багц-1: 6.76км авто зам, Багц-2: 201.08у/м төмөрбетон гүүр /260м зам/, Багц-3: 11.8км авто замыг 2020 онд дуусгана.
- **Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8 км авто зам:** Зам, Тээврийн Хөгжлийн яам нь авто замын барилгын гүйцэтгэгч БНХАУ-ын “Лонгжиан Роуд энд Бридж” ХХК-тай 2020 оны 3 дугаар сарын 27-ны өдөр гэрээ байгуулсан ба цар тахал буюу Ковид-19 вирусын улмаас хятад ажилчдыг Монгол улсад оруулах ажил түр хойшлогдож байгаа хэдий ч улаан шугам хүлээлгэн өгөх зэрэг бэлтгэл ажлыг хангаж байна.

Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын хэсэг тус бүрийн урт, тэдгээрийн санхүүжилт, барилгын ажлын Гүйцэтгэгч болон барилгын явц, ашиглалтын байдлын талаарх мэдээллийг доор үзүүлэв. Үүнд:

Чиглэл		Замын урт, км	Санхүүжүүлэгч	Гүйцэтгэгч	Тайлбар
Эхлэл	Төгсгөл				
Ярантын боомт	Булган сум	64	Монгол Улсын Засгийн газар	Шинжиан, Цонж аймгийн зам, гүүрийн компани	2006 онд ашиглалтад орсон
Булган сум	Тэмээн Хүзүү	60	Монгол Улсын Засгийн газар	Жиансу Жунжиан Жианшин ХХК	2016 онд ашиглалтад орсон
Тэмээн Хүзүү	Бага Улаан Даваа	110.8	Монгол Улсын Засгийн газар болон Азийн Хөгжлийн Банкны буцалтгүй тусламж (АХБ-ны 1-р үе шатны төсөл)	Чайна Жиансу Жианда Констракшн	2014 онд ашиглалтад орсон

Бага Улаан Даваа	Манхан сум	103.3	МУ-ын ЗГ болон АХБ зээл № 2847-MON(SF), (АХБ-ны 1-р үе шатны төсөл)	Чайна Жиансу Жианда Констракшн	2014-2015 онд ашиглалтад орсон
Манхан сум	Ховд	85.3	МУ-ын Засгийн газар болон БНХАУ-ын EXIM банкны хөнгөлөлттэй зээл	Чайна Гезоба Групп компани	2014 онд ашиглалтад орсон
Ховд	Шургийн гүүр	56.6	Азийн Хөгжлийн Банкны зээлийн № 3129-MON(SF), (2-р үе шатны төсөл)	Эйч Кэй Би Интернэйшнл Холдинг ХХК	2018 оны 10 сард ашиглалтад орсон
Шургийн гүүр	Хашаатын Даваа	50	Азийн Хөгжлийн Банкны зээлийн № 3129-MON(SF), (2-р үе шатны төсөл)	Чайна Хуаши Интерпрайзис ХХК	2018 оны 10 сард ашиглалтад орсон
Хашаатын Даваа	Толбо сум	60	Азийн Хөгжлийн Банкны зээлийн № 3129-MON(SF), (2-р үе шатны төсөл)	Чайна Хуаши Интерпрайзис ХХК	2019 оны 12 сард ашиглалтад орсон
Толбо сум	Өлгий	60	МУ-ын Засгийн газар болон БНХАУ-ын EXIM банкны хөнгөлөлттэй зээл	Чайна Гезоба Групп компани	2014 онд ашиглалтад орсон
Өлгий	Цагааннуур	70	Монгол Улсын Засгийн газар	Алтайн Зам ХХК	2013 онд ашиглалтад орсон
Цагааннуур	Улаанбайшинт	25.8	Азийн Хөгжлийн Банкны зээлийн № 3129-MON(SF), (2-р үе шатны төсөл)	Луньзянь роуд энд бридж ХХК	Барилгын бэлтгэл ажлууд хийгдэж байна
Төслийн зам	Мөст сум	20.3	Азийн Хөгжлийн Банкны зээлийн № 2847-MON(SF)	Хотгор Зам ХХК	баригдаж байгаа, ажлын явц 93.1%
Өлгий хотыг тойрон гарах 18.82км зам, 201у/м гүүрийн барилгын ажил	Багц-1	6.76	Азийн Хөгжлийн Банкны зээлийн № 3129-MON(SF), (2-р үе шатны төсөл)	Хотгор Зам ХХК	Барилгын ажил 05.01-ээс эхэлсэн
	Багц-2	201.08у/м гүүр, 260м зам	Азийн Хөгжлийн Банкны зээлийн № 3129-MON(SF), (2-р үе шатны төсөл)	Эйч Кэй Би Интернэйшнл Холдинг ХХК	Барилгын бэлтгэл ажлууд хийгдэж байна
	Багц-3	11.80 км зам, 4.5x4.65 м нүхэн гарц	Азийн Хөгжлийн Банкны зээлийн № 3129-MON(SF), (2-р үе шатны төсөл)	Эйч Кэй Би Интернэйшнл Холдинг ХХК	Барилгын бэлтгэл ажлууд хийгдэж байна



Дээрх баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замаас одоогоор ОХУ-тай хил залгаа хилийн боомт хүртэлх Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8 км зам баригдаж эхлээгүй

байгаа бөгөөд энэ замын баригдсанаар энэхүү корридорын авто зам бүхэлдээ баригдаж дуусах юм.

Төслийн авто зам нь Монгол улсын баруун хязгаарт Алтайн нурууны өндөрлөг уулсын бүсэд орших Баян-Өлгий, Ховд аймгийн нутаг дэвсгэрт баригдаж байгаа ба өндөр уулсын агаарын нөлөөгөөр хүйтэн уур амьсгалтай буюу намартаа эрт хүйтэрдэг, зундаа орой дулаардаг нь Хашаатын даваа-Толбо чиглэлийн зам барилгын ажлын улиралд тодорхой нөлөө үзүүлсэн.

Төслийн хүрээнд баруун бүстээ хамгийн өндөр даваа болох Бураатын даваанд 17м өндөр далангийн ажил гүйцэтгэсэн нь нэлээдгүй цаг, хугацаа зарцуулахад хүргэсэн болно.

Мөн Алтайн нурууг давж, Бодончийн хавцалд хад чулууны нуралтаас хамгаалсан торон хана, хэд хэдэн уулзвар замууд, нийт 4-6 хэсэгт амрах болон автомашины зогсоол барьсан, мөн үерийн хамгаалалтын болон хажуугийн бетон шуудуу зэргийг гүйцэтгэснээрээ онцлог юм.

Огцом эргэлт ихтэй, үзэгдэх орчин хязгаарлагдмал зэргээс шалтгаалан хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч замын дагуу анхааруулах, хориглох, заах, зохицуулах, мэдээлэх тэмдгүүд, туузан хашлага, дохионы шон зэргийг зураг төсөл, стандартын дагуу байрлуулсан.

Энэ төслийн хүрээнд тус бүр нь 30м - 150м урттай, нийт 1637.07м хүчитгэсэн төмөр бетон гүүрийг ажлын зураг, техникийн шаардлагын дагуу олон улсын болон дотоодын зөвлөхийн хяналтан дор барьсан байна. Эдгээр авто зам нь Монгол Улсын авто замын төлөвлөлтийн стандартын техникийн III ангилал, Азийн авто замын техникийн II ангиллын авто замын шаардлага, төлөвлөлтийн хурд, хэвтээ болон босоо төлөвлөлт, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах уулзвар, амрах талбай, автомашины зогсоолын шаардлагыг хангасан төвөгшил ихтэй газар оронд баригдсанаараа давуу талтай юм.

Төслийн техник, эдийн засгийн үндэслэлээр авто замыг бүхэлд нь барьснаар (i) 2020 он гэхэд авто замаар явах хөдөлгөөний дундаж хурд 40 км/цагаас 80 км/цаг болж нэмэгдэх (ii) Ярантын хилийн боомтоос Улаанбайшинтын хилийн боомт хүртэлхи зорчих хугацаа 8-10 цагаар багасах, (iii) Ярант болон Улаанбайшинтын хилийн боомт дахь ачаа, зорчигчийн хил, гаалиар нэвтрэх хугацаа 5 цагаар багасах, (iv) 2010-2020 онд Ярант болон Улаанбайшинтын хилийн боомтоор нэвтрэх хөдөлгөөний эрчим жилд ойролцоогоор 15%-иар тус тус нэмэгдэхээр тооцоологдсон.



Төслийн авто зам нь бүс нутгийн тээврийн сүлжээг сайжруулаад зогсохгүй, орон нутгийн ард, иргэд, оршин суугчдыг нийгэм, эрүүл мэнд, боловсрол болон бусад үйлчилгээнд бага зардлаар түргэн шуурхай нэвтрэх боломжоор хангах болно. Мөн зам хэрэглэгчдэд шууд ашгаа өгөхөөс гадна орон нутгийн эдийн засгийн хөгжил, ажлын байр шинээр бий болгоход тодорхой үр дүнгээ өгөх сайн талтай. Төслийн эргэн төлөгдөх эдийн засгийн дотоодын өгөөжийн хувь хэмжээ ойролцоогоор 16.25 хувь буюу хамгийн ашигтай хэмжээнд байна.

Төсөл хэрэгжүүлэх нэгж

2020 оны 5 дугаар сарын 20